

Чуулганы мэдээ

Өмнө ба одоо

1932

Ерөнхийлөгч Өүксийг төрсөн цагаас хойш Сүм хэр их өөрчлөгдсөнийг хараарай!



2024



7 ариун сүм

189 онцгойлон адислагдсан ариун сүм

700,000 Сүмийн гишүүн

146 ариун сүм барилга, төлөвлөлтийн үе шатандаа байгаа

17,000,000 Сүмийн гишүүд 170 улс оронд байдаг



“Бурхантай хийсэн бүх гэрээ Түүнд улам ойртох боломж юм.”

Тэргүүн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг



“Бурхан бидний залбирал бүрийг сонсдог гэдгийг гэрчилж байна.”

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч, ерөнхийлөгч Жэффри Р.Холланд



“Та бол [Бурханы] хүүхэд билээ. Тэр таны хэн болохыг мэддэг. Тэр та нарыг адислахыг хүсдэг.”

Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгч Сюзан Х.Портэр

Дэлхий даяар ерөнхий чуулганыг үзсэн нь



Надад ахлагч Дэ Фэогийн хэлсэн үг таалагдсан. Хэрэв бид итгэлтэй байвал Есүсийг сүнслэг

нүдээрээ харж чадна гэж тэр хэлсэн. Тэгээд бид амар амгаланг мэдэрч, Түүний Сүнс бидэнтэй байх болно.


Томас М., 7 настай, Испанийн Каталони



Би гэр

бүлийнхэнтэйгээ цагийг хамт өнгөрүүлдэг учраас чуулган надад онцгой байдаг. Бид үг хэлэгчдийг сонсож, гар урлал хийдэг.

Люси А., 10 настай, Кувейтийн Ал-Ахмади



Гэр бүлийнхэн маань чуулгандаа бэлдэж, Сүнсээр суралцахад туслаарай гэж Тэнгэрлэг Эцэгт

хандан залбирдаг. Бид ням гаргийн хамгийн сайхан хувцсаа өмсдөг. Бид хамтдаа чуулганаа үзэж, бүх дууг дагаж дуулдаг.

Харриэт О., 9 настай, Нигерийн Лагос муж

Шинэ ариун сүмүүд



Ерөнхийлөгч Нэлсон Ерөнхий чуулганы үеэр 15 шинэ ариун сүмийг зарласан! 15 цэгийг холбож зургийг дуусгаарай.

1. Францын Полинезийн Утуороа
2. Мексикийн Чихуахуа
3. Бразилын Флорианополис
4. Аргентины Розарио
5. Шотландын Эдинбург
6. Австралийн өмнөд бүсийн Брисбани
7. Бритиш Колумбийн Викториа
8. Аризонагийн Юма
9. Техасын өмнөд бүсийн Хюстон
10. Иовагийн Дэ Моин
11. Охайогийн Синсиннати
12. Хавайн Хонолулу
13. Ютагийн Баруун Жордан
14. Ютагийн Лихай
15. Венесуэлийн Маракайбо